



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 08 сарын 16 өдөр

Дугаар 47

Алтай

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 21 дүгээр зүйлийн 21.4 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Орон нутагт хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа аж ахуйн нэгж, гар аргаар ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагаатай танилцах, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн татвар хураамж, төлбөр, техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийгдсэн байдалд хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

1. Ажлын хэсгийн ахлагч Д.Амартүвшин- Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч

Гишүүдэд: Б.Баян-Эрдэнэ -/Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч, Тэргүүлэгч/
Д.Ойнбилэг -/Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч, Тэргүүлэгч/
Ж.Ганбат-/Есөнбулаг сумын Засаг дарга, аймгийн ИТХ-ын
Төлөөлөгч/

М.Баттулга-/Цагдаагийн газрын орлогч дарга/

Д.Эрхэмбаяр- МХГ-ын Улсын ахлах байцаагч

Т.Хүүхэндулам- Аймгийн ИТХ-ын ажлын албаны мэргэжилтэн

Э.Бямбаа- Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн

мэргэжилтэн

Я.Жаргалцэцэг- Байгаль орчин аялал жуулчлалын газрын

ахлах мэргэжилтэн

2. Хийгдэх ажлын удирдамж гарган аймгийн ИТХ-ын даргаар батлуулж ажиллан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд 2016 оны 09-р сарын 05-ны дотор танилцуулахыг ажлын хэсэг, дарга /Д.Амартүвшин/-д даалгасугай.

3. Ажлын хэсгийг ажиллах нөхцөл боломжоор хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

ДАРГА

Т.ГАНЗОРИГ

